

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

Төрийн албаны салбар зөвлөлөөс томилогдсон ажлын хэсэг 05 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын хүний нөөцийн ажил болон өргөдөл гомдлын тайланг гаргах чиглэлээр газрын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна. Энэ ажлын хүрээнд байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт шинэчлэгдэж, хувийн хэргийн бүрдэлд баяжилт хийсэн байна.

Засгийн газрын тогтоол, дүрэм, журамд нийцүүлэн батлагдсан цалингийн төсөвт багтаан ажиллах 20 хүний цалингийн санг шинэчилэн гаргаад байна.

Able программд шинээр ажилд орсон хүний нөөцийн мэдээллийг шинэчлэн оруулсан байна.

Нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх асуудлаар Сангийн яамнаас зөвшөөрсөн хариу ирж, гарын үсгийн баталгаа хийгдэж, санхүүгийн ажил хэвийн явагдаж байна.

Төрийн албаны салбар зөвлөлөөс жирэмсний амралтаа авсан төрийн захиргааны албан хаагчийн ажлыг түр орлон гүйцэтгүүлэх журмын дагуу иргэнээс сонгон ажиллуулах хариу өгснөөр түр томилох шийдвэр гаргуулсан байна.

“Ялалтын баяр” жагсаалын арга хэмжээнд байгууллагаас 11 ажилтан хамрагдсан байна.

Хэрэглэгчийн үнэлгээг Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээр хийлгэх болж асуулгыг МАА, ГТ, Хүнс чиглэлээр тус тус боловсруулж ажлыг эхлүүлэхэд бэлэн болгов.

Өөрийн эзэмшлийн зам талбайн орчны 50 м газрыг тус газрын 16 албан хаагчийг оролцуулж цэвэрлэгээг зохион байгуулав. Цэвэрлэгээгээр нийт 3 м3 хог цуглуулж ачуулав. Мөн хуваарийн дагуу 7-р багийн захиргаатай хамтран хариуцсан багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэд байгууллага, аж ахуй нэгжийг нийтийн цэвэрлэгээнд татан оролцуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

Хоёр:Салбарын хүрээнд

Мал аж ахуй салбар

Дархан-Уул аймгийн хэмжээнд төллөвөл зохих 152747 мянган толгой хээлтэгч мал байгаагаас 133048 мянган толгой хээлтэгч мал төллөж, нийт хээлтэгчийн 87 % төллөсөн байна. Үүнээс ингэний 29 %, гүүний 46 % , үнээний 71%, хонины 93%, ямааны 88% нь төллөж гүйцсэн байна. Төллөлтийн мэдээг ХХААЯ, МЭҮГ, Аймгийн ХБХ-т мэдээг хүргүүлэн ажиллаж байна. Том малын зүй бус хорогдолоор 927 толгой мал хорогдож, 448 толгой хээлтэгч мал зүй бусаар, 165 толгой мал хээл хаясан мэдээтэй байна.

4 дүгээр сарын 29-ний өдөр Тус газрын сургалтын танхимд “МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛАХ ТЕХНОЛОГИ” сэдэвт сургалтыг Глобал коммунитес ОУБ, УГТЭШХүрээлэнтэй хамтран зохион байгуулан Орхон, Шарын

гол, Хонгор сумдын 34 иргэнийг хамруулж, малын тэжээлийн ургамал тариалах технологи, ганд тэсвэртэй ургамлууд мөн жимс, жимсгэний тариалалт, гоёл чимэглэл, хамгаалалтын мод бут тариалалтын талаар онолын мэдлэг олголоо.

Мөн 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд тус газрын сургалтын танхимд **“МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛАХ ТЕХНОЛОГИ”, “МАЛЫН ГЕНЕТИК ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨТГӨХ”** сургалт, хэлэлцүүлгийг ХХААЯамны Малын удмын сангийн үндэсний төв, Глобол коммунитес ОУБ, УГТЭШХүрээлэнтэй хамтран зохион байгуулж 50 гаруй иргэн, малчид, фермерийг хамрууллаа. Хэлэлцүүлгээс гарсан малчдын саналыг ХХААЯамны Малын удмын сангийн үндэсний төвд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Монгол мал “Үндэсний хөтөлбөр”, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын 2015 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаж, газрын даргад танилцуулж, баталгаажууллаа.

“Гахай, тахиа, зөгийн аж ахуй эрхлэгчид”, Сүү, махны үхэр үржүүлэгчдэд” дэмжлэг үзүүлэх төслийн сонгон шалгаруулалтанд 18 иргэнд төсөл боловсруулах чиглэлээр зөвлөгөө өгч боловсруулсан төслийг ХХААЯаманд уламжлаад байна.

2005 оноос эхлэн Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, хөтөлбөр төслийн хүрээнд шинээр гаргасан болон сэргээн засварласан бэлчээрийн зориулалттай худгуудын ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавьж орон нутгийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах чиглэлээр албан тоот 4 суманд хүргүүлсэн байна.

Газар тариалангийн салбар

Аймгийн хэмжээнд тариалалтын ажил 4 дүгээр сарын 23-наас эхэлсэн бөгөөд 5-р сарын 18-ны байдлаар аймгийн хэмжээнд буудай 7677.6 га-д буюу 61.7 хувь, төмс 256 га буюу 40.9 хувь, хүнсний ногоо 510 га буюу 38.4 хувь, тосны ургамал 170 га буюу 5.7 хувь нийт 8613.6 га-д тариалалт хийж, 48.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Чацаргана суулгац зээлээр авах төслийн тендерт Шарын гол сумын иргэн Х.Төмөрбаатарын төсөл шалгарч, холбогдох материалыг ХХААЯ-нд хугацаанд хүргүүлснээр 6.6 сая төгрөгийн үнэ бүхий 3100 ширхэг чацарганы суулгацыг гэрээ байгуулан олголоо.

Хонгор сумын мэргэжилтэнтэй хамтран Газар тариалангийн үйлдвэрлэлтийн судалгааг шинэчлэн гаргалаа. Мөн Хонгор сумын МЭҮТ-тай хамтран үр тарианы Хонгор сумын 7, 8 дугаар бригадаар явж, үр тарианы тариалалтын явцтай танилцлаа. Томоохон аж ахуйн нэгжүүдийн тариалалт дууссан, учирч буй хүндрэл байхгүй байна.

Удирдах ажилтны зөвлөгөөнд Хаврын тариалалтын бэлтгэл ажил болон явцын талаар мэдээлэл бэлтгэн оролцсон байна.

Хүнсний үйлдвэрлэлийн салбар

Үйл ажиллагаа явуулж байгаа гурилын үйлдвэрүүдээс “Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа”-г тогтмол авч, ХХААЯ-д хүргүүлж байна. 2015.04.29-ны байдлаар үлдэгдэл улаан буудай 51,9

мян.тн, гурил 4,3 мян.тн, үйлдвэрлэлт 8,4 мян.тн, борлуулалт 7,5 мян.тн, 1 кг дээд гурил БГ055-980 төг, 1-р гурил БГ085 -770-780 төг, 2-р гурил БГ115 -400-510 төг, хивэгний үнэ 370-380 төгрөгний үнэтэй байна. 2015 оны 5-р сарын 30-ны байдлаар мэдээг шинэчлэн гаргана.

“Дархан meat фүүдс” ХХК-аас Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 1,0 мян.тн нөөцийн махыг 2015 оны 4-р сарын 02-ны өдөр хүлээн авч, орон нутгийн телевизээр ард иргэдэд сурталчилж, худалдан борлуулах ажлыг эхлүүлээ. Мах борлуулах хүсэлт ирүүлсэн 2 хүнсний дэлгүүрийн нэр, байршлыг “Дархан meat фүүдс” ХХК-д хүргэж, шийдвэрлүүлсэн байна. Улсын нөөцийн махны мэдээ 2015 оны 05-р сарын 22-ны өдрийн байдлаар 496,2 тн мах борлуулсан дүнтэй байна.

ХХААЯ-аас 2015 оны 4-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан "Кодексийн үндэсний чадавхийг дээшлүүлэх нь" төслийн хаалтын семинарт хамрагдаж, гарын авлагаар хууль эрхзүйн ном авсан байна.

Олон улсын санхүүгийн корпорац, МХЕГ-тай хамтран Орхон аймагт төвийн бүсийн 6 аймгийн МХГ-ын улсын байцаагч, хүнсний мэргэжилтэн, ажилтнуудыг хамируулсан “Эрсдэл суурилсан хяналт, шалгалт- хүнсний аюулгүй байдал” сэдэвт сургалтыг 2015 оны 4-р сарын 30-наас 5-р сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд аймгаас 2 улсын байцаагч, 5 ААН-ийн төлөөллийн хамт хамрагдаж, мэргэжил арга зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Мөн ХХААЯ-аас “Хоол үйлдвэрлэлийн салбарт хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь” сургалтыг 2015 оны 5-р сарын 14-15-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулсан бөгөөд аймгаа төлөөлөн 16 тогооч нар хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлж, сертификат авсан байна.

Төв, хангайн бүсийн аварга тогооч шалгаруулах уралдаан Орхон аймагт 5-р сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, аймгийг төлөөлөн 11 тогооч 4 төрөлд оролцож, 2 мөнгө, 1 хүрэл медаль, 2 тусгай байрын шагналт байранд орсон байна. Оролцсон 11 тогоочийн нэрсийг Аймгийн Засаг даргын орлогч баталж, байгууллагуудад нь албан тоот хүргэж дэмжлэг үзүүлж, аймгийн нэрэмжит шагналыг шийдвэрлэж өгсөн байна. Аймгийн нэрэмжит шагналыг Булган аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тогооч Ц.Батцэрэнд гардуулсан байна.

Дархан сумын ЗДТГ-аас 2015 оны 5-р сарын 06-ны өдөр зохион байгуулсан саалийн үнээтэй, сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлдэг Дархан сумын 17 иргэнд Хүнсний салбарын хууль эрхзүйн, сүү, сүүн бүтээгдэхүүнд хийх шинжилгээ, үүлдэр угсааг сайжруулах талаар МЭХ, МААХ, ХГТХ-ийн 3 мэргэжилтэн хамтран мэдээлэл хийсэн байна.

Мал эмнэлгийн салбар

Аймгийн Засаг даргын А/109 тоот захирамжаар хаврын мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Биокомбинат ТӨААТҮГ /Төрийн өмчит аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар/-аас хаврын урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах боом, цусан халдварт, дуут хавдар, шөвөг яр, гахайн мялзан, сахуу зэрэг өвчнөөс сэргийлэх вакциныг татан авч орон нутгийн Мал эмнэлгийн нэгжүүдэд хуваарилан олголоо. Урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн хувийн хэвшлийн 9 аж ахуй нэгжид орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр

19,6 сая төгрөгний урьдчилагаа санхүүжилтийг олголоо. Эдгээр арга хэмжээний үр дүнд одоогийн байдлаар 5 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд нийтдээ өссөн дүнгээр 95,2 мянган толгой малыг хамруулсан дүнтэй байна.

Малын бөөс, ширх, хачиг, цагаан хорхой зэрэг паразит өвчнөөс сэргийлэх туулгалт, боловсруулалтанд өссөн дүнгээр 359,5 мянган толгой малыг хамруулсан байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд аймгийн хэмжээнд мал, амьтадын халдварт, паразит өвчин гараагүй тайван байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ эхлэж байгаатай холбогдуулан орон нутгийн Мал эмнэлгийн анхан шатны нэгжүүдийн захирал эзэдийг цуглуулж цаг үеийн ажлыг хэрхэн зохион байгуулах талаар чиглэл, үүрэг өгч мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа. Хувийн хэвшлийн нэгжүүдийн 2014 онд хийсэн ажлыг үндэсэн болон нэмэлт 14 үзүүлэлтээр дүгнэсэн дүнгээ танилцуулж тэдний санал хүсэлтийг сонслоо. Ажлын үзүүлэлтээр тэргүүлсэн Урд-Эх, Ветмон, Арвинсүрэг үржих ХХК-ны захирал Б.Ширчинсүрэн, Н.Гэрэлцолмон, З.Алтансүвд нарыг ХХААГ-ын Өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаан урамшууллаа.

Оношлогоо шинжилгээний лабораторийг итгэмжлэлд хамруулах ажлыг оны эхнээс холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж 3 жилийн хугацаатай итгэмжлэлд хамрууллаа. Үүний үр дүнд тус лаборатори нь 56 нэр төрлийн оношлогоо шинжилгээг стандарт зааврын дагуу орон нутагтаа хийх итгэмжлэлтэй болж өмнөх итгэмжлэлийн хүрээг өргөтгөсөн байна.

Шинэлэг ажил:

Монгол улсын Ерөнхийлагчийн зарлигаар Монгол орон даяар “Сүүтэй Монгол” аянг 2015 оны 5-р сарын 1-нээс 12-р сарын 1 хүртэлх хугацаанд зарласан бөгөөд тус газрын хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. Энэ ажлын хүрээнд Малчин бүхий иргэдийн сүүнд үнэгүй аж ахуйн нэгжүүдэд аймгийн ИТХ-аар батлуулсан жишиг үнэлгээгээр шинжилгээ хийхээр болсон байна.

Дархан сумын 1,2-р багийн нутаг дэвсгэрт тодорхой бус шалтгаанаар үхэж хорогдсон үхрийн оношийг газар дээр нь задлан шинжилгээ хийж хордлогоор хорогдсон болохыг тогтоож холбогдох дээжийг аймгийн болон Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид шинжлүүлсэний үр дүнд химийн хорт бодис болох Хромоор хордсон болохыг тогтоосон байна. Улмаар химийн хорт бодис асарсан газрыг олж тогтоон хорт бодисыг саармагжуулах ажлыг аймгийн ОБХэлтэс, Дархан сумын ЗДТГ-тай хамтран хийсэний үр дүнд дахин мал хордоогүй байна.

Хоол үйлдвэрлэлийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад 2 мастер тогооч, 11 тогооч нарын хамт Орхон аймгийн талбайгаас цанын бааз хүртэл тогоочийн ажил, мэргэжлийг сурталчилсан жагсаалд оролцсон ба ахмадууд залуу тогооч нартаа ажил мэргэжлийн зөвлгөө өгснөөр бүсийн уралдаанд амжилттай оролцож, 2 мөнгө, 1 хүрэл, 2 тусгай байрын шагнал хүртсэн байна.

5-р сарын 30-д УБ хотод 1000 тогоочийн жагсаал болно.

Тулгамдаж буй асуудал

Хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай ХХААЯ-аас гаргасан богино хэмжээний дүрс бичлэгийг орон нутгийн телевизээр цацах зардал байхгүй байна.

Тайланг нэгтгэсэн: Бичиг хэрэг, архивын эрхлэгч Э.Мөнх-Эрдэнэ

Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ

БАТЛАВ: ГАЗРЫН ДАРГА...../Ц.ЭНХЖАРГАЛ /

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ 06 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Мал аж ахуйн хэлтэс				
1	Мал ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн мэдээг сумдаас авах	Сардаа	МААХ	Мэдээг үнэн зөв хугацаанд нь гаргасан байна.
2	Мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бусын хорогдлын мэдээг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх			Тайланг үнэн зөв гаргасан байна

3	2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулж батлуулах			Төлөвлөгөөтэй болсон байна.
4	Малын тэжээлийн хэрэгцээ, нөөц тооцон сум ААНэгжүүдэд тэжээл бэлтгэх даалгавар хүргүүлэх			Тэжээлийн хэрэгцээг тооцон даалгавар хүргүүлсэн байна
5	Бог малын үзлэг ангилалт зохион байгуулах			Үзлэг, ангилалтыг технологийн хугацаанд бүрэн хийсэн байна.

Мал эмнэлгийн хэлтэс

6	Мал амьтны боом, цусан халдварт, дуут хавдар, шөвөг яр, гахайн мялзан, сахуу зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 205,4 мянган толгой малыг хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ	Сардаа	МЭХ, орон нутгийн МЭҮН	Хамрагдвал зохих бүх малын 90-ээс доошгүй хувийг бүрэн хамруулсан байна.
7	“Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд хамруулах малын тоо, толгой түүнд шаардагдах вакцины тооцоог нэгтгэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг үржлийн газарт хүргүүлнэ	06-р сарын 10-ны дотор	МЭХэлтэс	Шаардагдах эм вакцины захиалгыг хүргүүлсэн байна.
8	Хээлтүүлэгч малын цусны шинжилгээ хийх ажлыг зохион бэлтгэл ажлын хүрээнд шаардагдах эм урвалж, оношлуурыг татан авах	06-р сарын 15-ны дотор	МЭХэлтэс	Шинжилгээ хийх бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.
9	Хөвсгөл аймагт зохион байгуулах Төвийн бүсийн Онол үйлдвэрлэлийн бага хуралд орон нутагт ажиллаж байгаа МЭҮТ, нэгжүүд болон МЭХэлтсийн мэргэжилтэнүүдийг зохион байгуулалттайгаар	06-р сарын 17-20-ны дотор	ХХАГ, МЭХэлтэс	Төвийн бүсийн ОУБХуралд 15-аас доош хүнийг хамруусан байна.

	хамруулах			
10	Урдьдчилан сэргийлэх тарилга хийсэн акт баримт, тарилгын цувааг нэгжүүдээс хүлээн авч хянах	06-р сарын 28-ны дотор	МЭХэлтэс, МЭҮН-үүд	Акт баримтыг бүрэн гаргуулан авсан байна.
11	Хагас жилийн мэдээ тайланг нэгтгэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг МЭҮГ-т хүргүүлэх	06-р сарын 30	МЭХэлтэс, МЭҮТасаг	Мэдээ, тайланг хугацаанд хүргүүлсэн байна.
Хүнс, газар тариалангийн хэлтэс				
11	“Хүнсний аюулгүй байдал” үндэсний болон дэд хөтөлбөрийн тайлан гаргах, нэгтгэлийг ХХААЯ-д хүргэх	ҮИ/15	Г.Тунгалаг	Хөтөлбөрийн үр дүн тооцсон байна.
12	Нөөцийн махны борлуулалтын мэдээ гаргах, дүгнэх	ҮИ/30	Г.Тунгалаг	Хангамжийг тооцон гаргасан байна.
13	Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа”-г гаргаж, ХХААЯ-д хүргэсэн байна.	ҮИ/30	Г.Тунгалаг	Мэдээг тулгаж, хангамжийг тооцсон байна.
14	Сүүтэй монгол аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг батлуулах	ҮИ сардаа	Г.Тунгалаг МЭХэлтэс	Хэрэгжүүлж эхэлсэн байна.
15	Тариалалтын мэдээг сумдаас авч нэгтгэн ХХААЯ-нд хүргүүлэх	Ү/22-28	О.Нэмэхбат	Тариалсан талбайн тоо хэмжээ гарсан байна.
16	Чацарганы суулгац авсан иргэнтэй гэрээ байгуулан тариалалтын явцтай газар дээр нь танилцах	Ү/26-28	О.Нэмэхбат	Тариалсан талбай, суулгацын хэмжээ гарсан байна.
17	Газрын даргын баталсан хуваарийн дагуу хүнсний ногооны үрийг сум, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох	Ү/22-28	О.Нэмэхбат	Хуваарийн дагуу олгосон байна.
18	Эхний хагас жилийн байдлаар холбогдох тайлангийн заалтыг гаргах	ҮИ/15-30	О.Нэмэхбат Г.Тунгалаг	Хугацаанд гаргасан байна.